

СУРГУУЛИЙН АВТОБУС ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ



Энэхүү журмын зорилго нь ТомЁ Сургуулийн сурагчдад автобусны үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой сургууль, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, сурагчид болон сурагчдын эцэг эх, асран хамгаалагчдын харилцааг зохицуулахад оршино.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Сургуулийн автобусны чиглэлийн хамрах хүрээ нь **Хавсралт 1**-ийн дагуу байна. Хамрах хүрээ нь автобусны үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн тоо, замын ачаалал, зардал зэргээс хамааран өөрчлөгдөх боломжтой бөгөөд өөрчлөлтийн тухай сурагчдын эцэг эх, асран хамгаалагчид урьдчилан мэдэгдэнэ.
- 1.2. Автобусны маршрут, зогсоол болон цагийн хуваарь урьдчилан батлагдан талуудад танилцуулагдана.
- 1.3. Сургуулийн автобус нь төв зам дагуу, тодорхой заасан зогсоолд сурагчдыг суулгаж, буулгана.
- 1.4. Өглөө сурагчдыг тогтсон зогсоолоос цагийн хуваарийн дагуу тогтсон цагт нь авах бөгөөд цагаасаа хоцорсон сурагчдыг хүлээх боломжгүй болно.
- 1.5. Замын ачааллаас шалтгаалан сурагчдыг зогсоолоос авах, зогсоолд буулгах цаг хойшлох боломжтой.
- 1.6. Автобус үйлчилгээг зөвхөн төлбөрийн үлдэгдэл тооцоогүй, бүртгэлтэй сурагчдад үзүүлнэ.
- 1.7. Хэрэв тухайн маршрутад суудал дүүрсэн тохиолдолд сурагчийг хүлээлэгт бүртгэн, автобусны суудлын дүүргэлт хангалттай болсон тохиолдолд шинээр автобус захиалах ажлыг сургуулийн захиргаа хийнэ.

2. Сургуулийн эрх, үүрэг

- 2.1. Сургуулийн автобусны үйлчилгээтэй холбоотой харилцааг зохицуулна.
- 2.2. Маршрутыг автобус үйлчилгээний байгууллагатай хамтран гаргана, өөрчлөлтийн талаар эцэг эх, асран хамгаалагч болон бусад талуудад урьдчилан цаг алдалгүй хүргэнэ.
- 2.3. Бага ангийн хүүхдийг орой тосож авалгүй, хүүхдийг эрсдэлд оруулсан үйлдэл нь 2 ба түүнээс дээш давтагдвал автобусны үйлчилгээг цуцлах хүртэл арга хэмжээг авах эрхтэй
- 2.4. Сургуулийн сурагчдад үйлчлэх автобусны үйлчилгээг зохион байгуулахдаа холбогдох хууль дүрэм журам, Монгол улсын “Сургуулийн автобусанд тавигдах MNS6444:2014 стандарт” шаардлагын дагуу үйл ажиллагаа явуулж буй компанийг сонгон шалгаруулж гэрээ байгуулж ажиллах
- 2.5. Сурагчдын гэрийн хаягийг тодорхой судлан гэрээ байгуулсан компанитай хамтран чиглэл маршрутаа гаргах
- 2.6. Автобусны үйлчилгээтэй холбоотой санал хүсэлтийг хүлээн авч зохих журмын дагуу талуудад тавьж шийдвэрлүүлж байх

Гурав. Гүйцэтгэгч компанийн үүрэг / Жолоочийн үүрэг/

- 3.1. Автобусны аюулгүй байдлыг бүрэн хариуцаж улирал тутам техникийн оношилгоо үзлэгт оруулах болон ажлын өмнөх өдөр автобусны бэлэн байдлыг тогтмол шалгаж хэвших
- 3.2. Үйлчилгээнд явж буй автобус цонхоо тогтмол хаах, хаалгыг хаасны дараа хөдлөх, автобусны цэвэр, тав тухтай байдлыг хангахад анхаарах
- 3.3. Маршрутын дагуу өглөө тогтсон цагт дурьдсан буудлаас нэр бүхий сурагчдыг /бага ангийн сурагчдыг эцэг эхээс/ хүлээн авч, орой тухайн буудалд хүргэж өгөх үйлчилгээг хариуцлагатай зохион байгуулна. Тухайн буудлаас хөдлөх цагт хүүхэд багтаж ирэхгүй бол 1-2 минут хүлээгээд хөдөлнө. Ирээгүй сурагчдыг анги удирдсан багш болон эцэг эхэд мэдэгдэх.
- 3.4. Автобусаар зорчих хугацаанд сурагчдын аюулгүй байдал эрүүл мэндийг бүрэн хариуцаж тээврийн хэрэгслийг жолоодох дүрэм журмыг чанд баримтлана.
- 3.5. Бага ангийн сурагчдыг автобуснаас буулган АУБ-д хүлээлгэн өгч, багшаас хүлээн авч автобусанд суулгаж байх
- 3.6. Хүүхэд бүрийн автобусаар үйлчлүүлэх картыг шалгаж оруулна.
- 3.7. Хүүхэдтэй эелдэг дотно харилцах, тэдэнд зөвлөн туслах анхаарал болгоомжтой зорчих болон аюулгүй ажиллагааны талаар мэдээлэл өгөх
- 3.8. Автобусаар үйлчлүүлж буй сурагчид, тэдний гэр бүл, анги удирдсан багштай холбоотой асуудал гарвал сургуулийн дотоод хяналтын менежер Х.Загдзүү-тэй холбогдох /Утас: 80201054/
- 3.9. Сурагч, зорчигчдын эрүүл ахуй, аюулгүй байдал, тав тухыг хангаж замын хөдөлгөөний дүрмийн дагуу үйлчилнэ.
- 3.10. Жолооч батлагдсан маршрутаас хазайхгүй байх, гаднын хүн тээвэрлэхгүй байх үүрэгтэй.
- 3.11. Сурагч, эцэг эх, асран хамгаалагч болон багш, ажилтнуудтай эелдэг боловсон харилцана.
- 3.12. Тухайн чиглэлийн сурагчдын ирц авах.

Дөрөв. Эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг

- 4.1. Эцэг эх, асран хамгаалагчид нь энэхүү журам, автобусны батлагдсан маршрут, цагийн хуваарь болон төлбөрийн мэдээлэлтэй бүрэн танилцсан байна.
- 4.2. Автобусны үйлчилгээ эхлэхээс 2 долоо хоногийн өмнө хүсэлтийг бөглөж илгээж төлбөр төлснөөр тухайн сурагчийн автобусны суудал баталгаажна.
- 4.3. Бага ангийн сурагчдыг эцэг эх, асран хамгаалагч нь зогсоолд 3-5 минутын өмнө биечлэн хүргэж өгч, орой биечлэн тосож авах үүрэгтэй. Сурагч нь тосож авах хүнгүйгээр буудалд бууснаас үүдэх ямар нэг эрсдэлийг сургууль болон автобус үйлчилгээ үзүүлэгч байгууллага хариуцахгүй болно.
- 4.4. Эцэг эхчүүд хүүхдэдээ автобус дотор биеэ зөв авч явах зааварчилгааг өгсөн байна.
- 4.5. Сурагч өвдсөн болон бусад шалтгаанаар автобусанд суухгүй тохиолдолд эцэг эх, асран хамгаалагч нь өмнөх өдөр эсвэл өглөө эрт АУБ болон хариуцсан ажилтанд мэдэгдэнэ.

- 4.6. Хэрэв нэгэнт байгуулсан автобусны гэрээг цуцлах бол үйлчилгээг зогсоох өдрийг эцэг эх, асран хамгаалагч нь сургуулийн захиргаанд албан ёсоор бичгээр 1-ээс доошгүй долоо хоногийн өмнө мэдэгдэнэ.
- 4.7. Бага ангийн сурагчдыг автобусны буудал дээр биечлэн хүргэж жолоочид хүлээлгэж өгөх, тухайн буудлаас хүлээн авах
- 4.8. Дунд ахлах ангийн хүүхэдтэй эцэг эх хүүхдээ дурьдсан цагт буудал дээр очсон байх болон цагтаа буцаж ирсэн эсэхэд анхаарах, шаардлагатай бол анги удирдсан багштай холбогдох
- 4.9. Хүүхдээ автобусны буудал дээр даарах хөрөхөөс урьдчилан сэргийлж дулаан хувцас, малгай өмсгөж явуулахад анхаарах
- 4.10. Унааны төлбөрийг улирлаар нь цаг хугацаанд нь төлөх ба дансаар шилжүүлэх
- 4.11. Хүүхдээ автобусанд сууж амжихгүй болсон тохиолдолд жолоочид болон анги удирдсан багшид урьдчилан 20-30 минутын өмнө мэдэгдэх, хүндэтгэн үзэх шалтгаанаар хичээлдээ явах боломжгүй тохиолдолд өмнөх өдөр нь АУБ болон жолоочид мэдэгдэх
- 4.12. Автобусны үйлчилгээ, техник аюулгүй ажиллагаа, үнэ хөлстэй холбоотой санал хүсэлт байвал хариуцсан менежер Х.Загдзүү-тэй холбогдох. /Утас: 80201054/
- 4.13. Автобусны төлбөрийг тухай бүрт нь хариуцлагатайгаар төлж барагдуулах ба суудлаа баталгаажуулаагүйгээр зорчих боломжгүйг анхаарах

Тав. Сурагчийн үүрэг

- 5.1. Сурагч өглөө автобусны зогсоол дээр 3-5 минутын өмнө ирсэн байна. Орой хичээл тарсны дараа автобус хөтлөх цагаас 5 минутын өмнө автобусанд суусан байна.
- 5.2. Сурагч зөвхөн сургууль дээр буух, гэртээ харих тогтсон маршрутаар, заасан зогсоол дээр бууна.
- 5.3. Сурагч автобусаас буугаад өөрийн аюулгүй байдлыг хариуцах ба зам хөндлөн гардаг бол автобусны араас 3 метрийн зай барьж гарцаар гарна.
- 5.4. Сурагчид бусдад саад учруулахгүйгээр биеэ зөв авч явна.
- 5.5. Дунд ахлах ангийн хүүхэдтэй эцэг эх хүүхдээ дурьдсан цагт буудал дээр очсон байх болон цагтаа буцаж ирсэн эсэхэд анхаарах, шаардлагатай бол анги удирдсан багштай холбогдох
- 5.6. Хүүхдээ автобусны буудал дээр даарах хөрөхөөс урьдчилан сэргийлж дулаан хувцас, малгай өмсгөж явуулахад анхаарах
- 5.7. Бага ангийн сурагчид гэр бүлийнхээ хэн нэгнээр хүргүүлэх мөн тэднээр тосуулж харина. Хүн тосоогүй бол жолоочийг гэр бүлийнхэнтэйгээ холбоо бариулна.
- 5.8. Ахлах дунд ангийн сурагчид цагийг нарийн баримтлан дурьдсан цагт өглөө буудал дээр, орой сургуулийн үүдэнд бэлэн ирсэн байж автобусандаа сууна. Хоцорсон тохиолдолд жолооч болон ангийн багшид урьдчилан мэдэгдэнэ.
- 5.9. Сурагч бүр автобусны картаа үзүүлж сууна.
- 5.10. Биед эвтэй дулаан хувцас, малгай бээлийгээ өмсөж сургуульдаа явж байна
- 5.11. Автобусанд суухын өмнө болон автобусаас буугаад анхаарал болгоомжтой харьж байх

Зургаа. Автобус хариуцсан ажилтны үүрэг

- 6.1. Автобусны үйлчилгээ авч буй сурагчдын мэдээллийг бүртгэлийг жолоочдод хүлээлгэн өгөх
- 6.2. Автобусны маршрут, цагийн хуваарьт өөрчлөлт гарсан тохиолдолд мэйл болон нэгдсэн группээр эцэг эх, асран хамгаалагчдад мэдээлэл өгөх.
- 6.3. Шаардлагатай тохиолдолд сурагчид руу ярьж мэдээлэл өгөх
- 6.4. Автобусны жолоочид тухайн чиглэлийн сурагчдын мэдээлэл / Овог, нэр, утасны дугаар, буух, суух зогсоолын нэр/ зэрэг зүйлсийг хэвлэж өгөх.
- 6.5. Автобусны үйлчилгээний асуудлаар тавьж буй эцэг эхийн санал хүсэлтийг сургуулийн захиргаанд уламжлах үүрэгтэй. Харин дур мэдэн шийдвэр гаргахгүй.

Долоо. Төлбөр тооцоо

- 7.1. Автобусны өглөө авч, орой хүргэх (хоёр талдаа) нэг өдрийн хөлс нь Яармаг, Нисэх чиглэлд **10'000** төгрөг, бусад чиглэлд **12'000** төгрөг байх ба шатахуун, түлшний үнийн өөрчлөлтөөс шалтгаалан энэ үнэнд өөрчлөлт орох боломжтой бөгөөд өөрчлөлтийн тухай сурагчдын эцэг эх, асран хамгаалагчид урьдчилан мэдэгдэнэ. Мөн нэг талдаа үйлчилгээ үзүүлэх боломжгүй.
- 7.2. Автобусны төлбөрийг хичээлийн улирлаар шаардлагатай бол жилээр тооцон урьдчилан заасан хугацаанд дансаар шилжүүлж суудлаа баталгаажуулна.
- 7.3. Өвчтэй, чөлөөтэй, автобусаас хоцорсон зэрэг автобусны үйлчилгээ аваагүй үеийн төлбөрийг хасч тооцохгүйг анхаарна уу. Хэрвээ сурагч нь дарааллан 7 ба түүнээс дээш хоногоор өвчтэй байсан бол эмчийн магадалгааг үндэслэн өвчтэй байсан хоногийн төлбөрийг дараа улирлын төлбөрөөс хасч тооцно.

СУРГУУЛИЙН АВТОБУСНЫ ЧИГЛЭЛ

Grow your Dreams
at TomYo School2025-2026 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН
АВТОБУСНЫ БҮРТГЭЛ

ЗАЙСАН ЧИГЛЭЛ		БАЯНМОНГОЛ ЧИГЛЭЛ		ХАНХИЛЛС ЧИГЛЭЛ		ЯАРМАГ ЧИГЛЭЛ		НИСЭХ ЧИГЛЭЛ	
Зогсоол	Суух цаг	Зогсоол	Суух цаг	Зогсоол	Суух цаг	Зогсоол	Суух цаг	Зогсоол	Суух цаг
Цэлмэг хотхон	6:25	Замын цагдаа	6:20	Ханхиллс	6:30	Гарден сити	6:35	Элеганс хотхон	7:00
UB таун	6:27	Сүмбэр орд	6:27	Хүннү 2222	6:23	Нутгийн буян	6:40	Викториан таун	7:02
Ази фарм	6:35	Баянмонгол	6:30	Хүннү	6:35	Англи сургууль	6:50	Хүрээ хотхон	7:04
Зайсан эцэс	6:40	Солонгос элчин	6:37	Удирдлагын/ак-2	6:41	Дрийм плаза	7:05	Дөрвөн бэрх	7:10
Хатан туул	6:46	Car wash	6:40	Токио таун	6:45	Сургууль	7:40	Буянт-Ухаа 2	7:16
Хийморь хотхон	6:50	Нарны хороолол	6:42	Хурд	6:48			Шинэ Яармаг	7:18
Вива сити	6:53	Алтай хотхон	6:45	Тэмээтэй хөшөө	6:50			Нүхт эргэлт	7:25
Хүннү молл	6:55	Эрэл	6:48	Хүннү молл	6:55			Сургууль	7:40
Номин моторс	7:02	Вивасити	7:02	Номин моторс	7:02				
Сургууль	7:40	Сургууль	7:40	Сургууль	7:40				

Төлбөрийн мэдээлэл:

- Яармаг чиглэл: 10,000₮
- Нисэх чиглэл: 10,000₮
- Зайсан чиглэл: 12,000₮
- Баянмонгол чиглэл: 12,000₮
- Ханхиллс чиглэл: 12,000₮

Бүртгэлийн процесс:

- Бүртгэлийн линкээр нэвтэрч таарч буй чиглэлдээ заавал бүртгүүлнэ.
- Бүртгүүлсэн мэйлээр бид танд дэлгэрэнгүй мэдээлэл илгээх болно.
- Мэдээлэлтэй танилцаж, суудлаа баталгаажуулж, гэрээ хийнэ.



ЗАЙСАН ЧИГЛЭЛ		БАЯНМОНГОЛ ЧИГЛЭЛ		ХАНХИЛЛС ЧИГЛЭЛ	
Зогсоол	Суух цаг	Зогсоол	Суух цаг	Зогсоол	Суух цаг
Цэлмэг хотхон	6:25	Замын цагдаа	6:20	Ханхиллс	6:30
UB таун	6:27	Сүмбэр орд	6:27	Хүннү 2222	6:23
Ази фарм	6:35	Баянмонгол	6:30	Хүннү	6:35
Зайсан эцэс	6:40	Солонгос элчин	6:37	Удирдлагын/ак-2	6:41
Хатан туул	6:46	Car wash	6:40	Токио таун	6:45
Хийморь хотхон	6:50	Нарны хороолол	6:42	Хурд	6:48
Вива сити	6:53	Алтай хотхон	6:45	Тэмээтэй хөшөө	6:50
Хүннү молл	6:55	Эрэл	6:48	Хүннү молл	6:55
Номин моторс	7:02	Вивасити	7:02	Номин моторс	7:02
Сургууль	7:40	Сургууль	7:40	Сургууль	7:40

ЯАРМАГ ЧИГЛЭЛ

НИСЭХ ЧИГЛЭЛ

Зогсоол	Суух цаг	Зогсоол	Суух цаг
Гарден сити	6:35	Элеганс хотхон	7:00
Нутгийн буян	6:40	Викториан таун	7:02
Англи сургууль	6:50	Хүрээ хотхон	7:04
Дрийм плаза	7:05	Дөрвөн бэрх	7:10
Сургууль	7:40	Буянт-Ухаа 2	7:16
		Шинэ Яармаг	7:18
		Нүхт эргэлт	7:25
		Сургууль	7:40